АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/133/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Цэцэрлэг хот

2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 70332680 Цахим хаяг:Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор: П.Энхжаргал
Утас: 99743112
Цахим хаяг: enkhjargalp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт....2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....9
3. Аудитын тайлан....10
3.1 Ерөнхий зүйл....10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....10
3.4 Материаллаг байдал....11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....13
3.8 Аудитын гол асуудал....13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....14
**3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**....14
3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал....14
4. Аудитын илрүүлэлт....14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....15

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

## 1.Аудитын санал дүгнэлт

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.24 № 66
танай ____________-ны № ______________-т

ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
П.ЧУЛУУНБАТ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,473,688.00** | **58,968,088.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **51,473,688.00** | **58,968,088.00** |
| **35400** | **Хангамжийн материал** | **51,473,688.00** | **58,968,088.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 81,500.00 | 81,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 49,542,188.00 | 56,636,588.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,850,000.00 | 2,250,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,959,107,450.80** | **1,979,102,584.14** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,959,107,450.80** | **1,979,102,584.14** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,907,031,117.36** | **1,928,671,250.66** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 961,585,080.00 | 971,085,080.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -61,504,951.04 | -73,397,226.64 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 150,652,875.00 | 150,652,875.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -112,615,680.70 | -96,869,472.34 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 128,527,346.00 | 84,831,884.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -79,162,073.09 | -36,575,320.63 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 218,123,007.02 | 189,088,953.02 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -122,362,804.49 | -58,971,748.61 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,113,234,419.00 | 1,145,151,380.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -290,475,450.34 | -347,354,503.14 |
| 39217 | Ном | 1,029,350.00 | 1,029,350.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **52,076,333.44** | **50,431,333.48** |
| 39301 | Програм хангамж | 8,547,000.00 | 4,935,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5,134,666.56 | -3,167,666.52 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 48,664,000.00 | 48,664,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,010,581,138.80** | **2,038,070,672.14** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,010,581,138.80** | **2,038,070,672.14** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,010,581,138.80** | **2,038,070,672.14** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 520,124,120.00 | 520,124,120.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **979,398,679.76** | **1,017,441,901.14** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 880,811,295.15 | 989,952,367.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 98,587,384.61 | 27,489,533.34 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 511,058,339.04 | 500,504,651.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,010,581,138.80** | **2,038,070,672.14** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **713,733,867.00** | **638,249,908.02** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **283,756,843.00** | **157,407,619.02** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **283,756,843.00** | **157,407,619.02** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **504,000.00** | **1,600,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 504,000.00 | 1,600,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 232,277,843.00 | 153,452,619.02 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 50,975,000.00 | 2,355,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **429,977,024.00** | **480,842,289.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **49,177,824.00** | **28,957,089.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 49,177,824.00 | 28,957,089.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **380,799,200.00** | **451,885,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 380,799,200.00 | 451,885,200.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **574,756,446.95** | **609,880,374.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **574,756,446.95** | **609,880,374.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **518,861,985.50** | **504,166,075.68** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **230,011,984.64** | **222,087,114.00** |
| 210101 | Үндсэн цалин | 230,011,984.64 | 222,087,114.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **29,191,570.91** | **29,071,903.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,930,271.97 | 20,366,886.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,315,299.01 | 2,263,517.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,852,299.93 | 1,800,735.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 463,100.00 | 759,239.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,630,600.00 | 3,881,523.98 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **11,798,234.00** | **11,842,970.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,052,134.00 | 2,203,810.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,446,100.00 | 9,389,160.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 250,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **74,706,248.00** | **31,646,583.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,947,200.00 | 3,927,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,070,048.00 | 22,332,783.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,999,700.00 | 1,835,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 216,800.00 | 167,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 350,000.00 | 995,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,322,500.00 | 2,388,100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 49,800,000.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **800,000.00** | **3,675,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 2,875,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **25,258,260.00** | **9,329,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,176,860.00 | 2,855,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,081,400.00 | 6,473,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,372,000.00** | **2,946,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,372,000.00 | 2,946,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **7,528,365.00** | **9,430,501.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,044,875.00 | 8,394,287.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,188,800.00 | 879,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 110,000.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 160,000.00 | 77,574.00 |
| 210807 | Газрын төлбөр | 24,690.00 | 24,690.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **133,195,322.95** | **184,137,004.68** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,238,000.00 | 38,629,519.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,410,000.00 | 0.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 124,547,322.95 | 145,507,485.68 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **55,894,461.45** | **105,714,299.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **22,378,800.00** | **601,600.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,312,400.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,066,400.00 | 601,600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **33,515,661.45** | **105,112,699.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 33,515,661.45 | 105,112,699.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **138,977,420.05** | **28,369,533.34** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **40,390,035.44** | **880,000.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 40,390,035.44 | 880,000.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **98,587,384.61** | **27,489,533.34** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **520,124,120.00** | **553,508,580.04** | **838,361,054.15** | **1,911,993,754.19** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **42,450,241.00** | **42,450,241.00** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **520,124,120.00** | **553,508,580.04** | **880,811,295.15** | **1,954,443,995.19** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.00** | **-42,450,241.00** | **0.00** | **-42,450,241.00** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **98,587,384.61** | **98,587,384.61** |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **520,124,120.00** | **511,058,339.04** | **979,398,679.76** | **2,010,581,138.80** |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **520,124,120.00** | **511,058,339.04** | **979,398,679.76** | **2,010,581,138.80** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 10,553,688.04 | 10,553,688.04 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **520,124,120.00** | **511,058,339.04** | **989,952,367.80** | **2,021,134,826.84** |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | -10,553,688.04 | 0.00 | -10,553,688.04 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 27,489,533.34 | 27,489,533.34 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **520,124,120.00** | **500,504,651.00** | **1,017,441,901.14** | **2,038,070,672.14** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **430,481,024.00** | **482,442,289.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **504,000.00** | **1,600,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **504,000.00** | **1,600,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **504,000.00** | **1,600,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 504,000.00 | 1,600,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **429,977,024.00** | **480,842,289.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **49,177,824.00** | **28,957,089.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 49,177,824.00 | 28,957,089.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **380,799,200.00** | **451,885,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 380,799,200.00 | 451,885,200.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **393,481,124.00** | **469,512,289.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **393,481,124.00** | **469,512,289.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **337,586,662.55** | **363,711,590.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **230,011,984.64** | **222,087,114.00** |
| 210101 | Үндсэн цалин | 230,011,984.64 | 222,087,114.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **29,191,570.91** | **29,071,903.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,930,271.97 | 20,366,884.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,315,299.01 | 2,263,519.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,852,299.93 | 1,800,735.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 463,100.00 | 418,574.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,630,600.00 | 4,222,189.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **12,198,234.00** | **12,242,970.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,052,134.00 | 2,203,810.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,846,100.00 | 9,789,160.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 250,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **22,247,919.00** | **23,749,850.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,687,200.00 | 3,687,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,849,269.00 | 15,001,450.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,899,700.00 | 1,835,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 216,800.00 | 376,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 994,950.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,600,000.00 | 1,850,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **800,000.00** | **3,675,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 2,875,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,957,360.00** | **9,329,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,157,360.00 | 2,855,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | 6,473,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,372,000.00** | **2,946,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,372,000.00 | 2,946,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,297,594.00** | **9,928,254.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,814,104.00 | 8,892,040.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,188,800.00 | 879,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 110,000.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 160,000.00 | 77,574.00 |
| 210807 | Газрын төлбөр | 24,690.00 | 24,690.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **25,510,000.00** | **50,681,499.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,100,000.00 | 50,681,499.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,410,000.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **55,894,461.45** | **105,800,699.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **22,378,800.00** | **688,000.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,312,400.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,066,400.00 | 688,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **33,515,661.45** | **105,112,699.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 33,515,661.45 | 105,112,699.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **36,999,900.00** | **12,930,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **36,999,900.00** | **12,930,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **36,999,900.00** | **12,930,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **36,999,900.00** | **12,930,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 36,999,900.00 | 12,930,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-36,999,900.00** | **-12,930,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0.00** | **0.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөг/

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **452,385,200.00** | **348,372,501.00** | **104,012,699.00** | **77.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **385,885,200.00** | **338,872,501.00** | **47,012,699.00** | **87.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **384,685,200.00** | **338,184,501.00** | **46,500,699.00** | **87.91** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **238,743,500.00** | **222,087,114.00** | **16,656,386.00** | **93.02** |
| 210101 | Үндсэн цалин | 238,743,500.00 | 222,087,114.00 | **16,656,386.00** | **93.02** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,230,400.00** | **29,071,903.00** | **3,158,497.00** | **90.20** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,680,600.00 | 20,366,884.60 | **2,313,715.40** | **89.80** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,387,500.00 | 2,263,519.24 | **123,980.76** | **94.81** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,909,900.00 | 1,800,735.25 | **109,164.75** | **94.28** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 477,500.00 | 418,574.49 | **58,925.51** | **87.66** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,774,900.00 | 4,222,189.42 | **552,710.58** | **88.42** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **14,000,000.00** | **12,242,970.00** | **1,757,030.00** | **87.45** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,700,000.00 | 2,203,810.00 | **1,496,190.00** | **59.56** |
| 210302 | Түлш, халаалт | 10,000,000.00 | 9,789,160.00 | **210,840.00** | **97.89** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 250,000.00 | **50,000.00** | **83.33** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **23,437,100.00** | **23,413,400.00** | **23,700.00** | **99.90** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,687,100.00 | 3,687,100.00 | **0.00** | **100.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,000,000.00 | 14,665,000.00 | **-665,000.00** | **104.75** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,500,000.00 | 1,835,000.00 | **665,000.00** | **73.40** |
| 210404 | Ном, хэвлэл | 400,000.00 | 376,300.00 | **23,700.00** | **94.08** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,000,000.00 | 1,000,000.00 | **0.00** | **100.00** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,850,000.00 | 1,850,000.00 | **0.00** | **100.00** |
| **2105** | **Нормативт зардал** | **800,000.00** | **800,000.00** | **0.00** | **100.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 | **0.00** | **100.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,749,400.00** | **12,399,000.00** | **350,400.00** | **97.25** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 | 4,650,000.00 | **350,000.00** | **93.00** |
| 210604 | Урсгал засвар | 7,749,400.00 | 7,749,000.00 | **400.00** | **99.99** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,500,000.00** | **2,946,000.00** | **4,554,000.00** | **39.28** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,500,000.00 | 2,946,000.00 | **4,554,000.00** | **39.28** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,574,800.00** | **3,534,614.00** | **1,040,186.00** | **77.26** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,016,000.00 | 2,498,400.00 | **517,600.00** | **82.84** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,188,800.00 | 879,500.00 | **309,300.00** | **73.98** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 110,000.00 | 54,450.00 | **55,550.00** | **49.50** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 160,000.00 | 77,574.00 | **82,426.00** | **48.48** |
| 210807 | Газрын төлбөр | 100,000.00 | 24,690.00 | **75,310.00** | **24.69** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **50,650,000.00** | **31,689,500.00** | **18,960,500.00** | **62.57** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,500,000.00 | 31,689,500.00 | **14,810,500.00** | **68.15** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,150,000.00 | 0.00 | **4,150,000.00** | **0.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,200,000.00** | **688,000.00** | **512,000.00** | **57.33** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,200,000.00** | **688,000.00** | **512,000.00** | **57.33** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,200,000.00 | 688,000.00 | **512,000.00** | **57.33** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **66,500,000.00** | **9,500,000.00** | **57,000,000.00** | **14.29** |
| 220001 | Барилга байгууламж | 20,000,000.00 | 0.00 | **20,000,000.00** | **0.00** |
| 221001 | Их засвар | 9,500,000.00 | 9,500,000.00 | **0.00** | **100.00** |
| 222001 | Тоног төхөөрөмж | 37,000,000.00 | 0.00 | **37,000,000.00** | **0.00** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **452,385,200.00** | **348,372,501.00** | **104,012,699.00** | **77.01** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **367,236,400.00** | **346,772,501.00** | **20,463,899.00** | **94.43** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 367,236,400.00 | 346,772,501.00 | **20,463,899.00** | **94.43** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **85,148,800.00** | **1,600,000.00** | **83,548,800.00** | **1.88** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 1,600,000.00 | **-1,100,000.00** | **320.00** |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 84,648,800.00 | 0.00 | **84,648,800.00** | **0.00** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **9,042.00** | **51.00** | **8,991.00** | **0.56** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **25.00** | **25.00** | **0.00** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 7.00 | 7.00 | **0.00** | **100.00** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 13.00 | **0.00** | **100.00** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | **0.00** | **100.00** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **28,957,089.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **28,957,089.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **28,957,089.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **336,450.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 336,450.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,875,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | 2,875,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **360,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 360,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,393,640.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,393,640.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **18,991,999.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,991,999.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **28,957,089.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **28,957,089.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 28,957,089.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэрлэг сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03/29 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэцэрлэг сумын ЗДТГ нь Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр, Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнтэй нийцүүлэн гаргасан нутгийн захиргааны шийдвэрүүдэд хяналт тавьж биелэлтийг хангуулахын тулд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
-

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэрлэг сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурилаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.
Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 452.4 сая төгрөгөөс 1%-иар буюу 4.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 %-иар буюу буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 27.5 сая төгргөөр буюу 1.4 хувиар өссөн байна. Оны эхний үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс байхгүй байна.

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4=3-2 | |
| Бараа материал | 51.4 | 58.9 | 7.5 | 14.6 |
| Үндсэн хөрөнгө | 1959.1 | 1979.1 | 20.0 | 1.0 |
| **Нийт хөрөнгө** | **2010.5** | **2038.0** | **27.5** | **1.4** |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2010.5 | 2038.0 | 27.5 | 1.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2010.5** | **2038.0** | **27.5** | **1.4** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- *Бараа материал эхний үлдэгдлээс 7.5 сая төгрөг буюу 14.6 хувиар өссөн байна.*

Бараа материалын данс нь 51.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 82.7 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй ирсэн 2.4 сая төгрөгөөр нийт 85.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 77.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 58.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Үндсэн хөрөнгө эхний үлдэглээс 20.0 сая төгрөг буюу 1.0 хувиар өссөн байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 1,959.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 12.9 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 153.4 сая төгрөгийн акталсан хөрөнгийг орлогод авч нийт 166.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 145.5 сая төгрөгийн элэгдэлийн зардлаар буурч 1,979.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой бөгөөд тайлант хугацаанд 27.5 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

| Код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **713.7** | **638.2** | **-75.5** |
| 2 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.5 | 1.6 | 1.1 |
| 3 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 283.2 | 155.8 | -127.4 |
| 4 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 49.2 | 28.9 | -20.3 |
| 5 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 380.8 | 451.9 | 71.1 |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **574.7** | **609.9** | **35.2** |
| **7** | Бараа, ажил үйлчилгээний зардал | 478.4 | 503.3 | 24.9 |
| **8** | Урсгал шилжүүлэг | 55.9 | 105.7 | 49.8 |
| **9** | Үндсэн хөрөнгө худалдсны гарз | 40.4 | 0.9 | -39.5 |
| **10** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **98.6** | **27.4** | **-71.2** |

Цэцэрлэг сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 75.5 сая төгрөг буюу 10.6 хувиар буурсан нь үнэ төлбөргүй орлого, нэмэлт санхүүжилтийн орлоготой холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 382.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.
Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 69.5 сая төгрөгөөр өсгөж нийт зардлыг 452.3 сая төгрөгөөр хянаж баталжээ. Энэ нь ИТХ-ын тэргүүлэгчдээс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 452.3 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 367.2 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 84.6 сая төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.5 сая төгрөгийн санхүүжилт авч 348.3 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 104.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Харин үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.5 сая төгрөгөөр төлөвсөснийг гүйцэтгэлээр 1.6 сая төгрөг төвлөрч 1.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний бусад зардлаас 46.5 сая төгрөг, урсгал шилжүүлгээс 0.5 сая төгрөг, хөрөнгийн зардлаас 57.0 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.
Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.
Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 28.9 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас 10.8 сая төгрөгийн санхүүжилт ирснийг сумын Засаг даргын захирамжаар ковид 19 цар тахлын тусгаарлах байрны хоол, хүнс, шатахуун, бусад зардалд зарцуулсан байна.

- Аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогод зориулж 1.0 сая төгрөг, Ар ус Ундарга ХХК-аас усны төлбөрт 5.7 сая төгрөг, аймгийн ХХААГ-аас үлийн цагаан огтоно устгах зардалд 12.0 сая төгрөг, аймгийн ГХБЗХГ-аас хүүхэд хамгааллын зардалд 0.2 сая төгрөг, аймгийн ЗДТГ-аас цэрэг хүргэлтийн шатахуунд 0.3 сая төгрөг, аймгийн ИТХ-аас санхүүгийн дэмжлэг 0.3 сая төгрөг, нийт 19.5 сая төгрөгийн санхүүжилтийг сумын Засаг даргын захирамж шийдвэрийн дагуу зарцуулсан байна.

- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу иргэн, аж ахуйн нэгжүүдээс ковид 19 цар тахалтай холбоотой 9.4 сая төгрөгийн хандивын орлого төвлөрснийг сумын Засаг даргын 2021 оны захирамжийн дагуу тусгаарлах байрны хоол, хүнс, аж ахуйн материал болон шатахууны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд иргэдэд ковидоос урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж хүргүүлэх, хөдөлгөөнт эргүүл хийх, өөр бусад ажлаар хувийн автомашинд 9.8 сая төгрөгийн шатахуун зарцуулж ажилласан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 452.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 77.0 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал урамшуулал олгоогүй, автомашин худалдан аваагүй байна.
2. Суудлын автомашин ашиглалтын хувьд: Тус байгууллага нь 2011-2017 онуудад үйлдвэрлэгдсэн 78.0 сая төгрөгийн төсөв бүхий 3 автомашин ашигладаг бөгөөд жилийн шатахууны зардалд 15.0 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 5.1 сая төгрөгийг тус тус зарцуулж, үндсэн орон тооны 1 жолоочтой байна.
3. Ковид-19 цар тахалтай холбоотой иргэдээс 9.4 сая төгрөгийн мөнгөн, 2.4 сая төгрөгийн мөнгөн бус хандив хүлээн авч зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цэцэрлэг сумын ЗДТГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 145 мэдээллээс 141 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.
*<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.*

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд батлагдсан төсвийн 57.3 хувь буюу 104.0 сая төгрөгийн хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт нийцэж нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цэцэрлэг сумын ЗДТГ-д завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналт, үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацаатай холбоотой зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж биелэлтийг Цэцэрлэг сумын ЗДТГ-ын даргын 2021.05.31-ны 03/431 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн жинхэнэ албан хаагчийн сул оронд хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулсан эсэхийг шалгах

## 4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

-----oOo-----

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Цэцэрлэг сумын ЗДТГ | | | | | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 2 | Цэцэрлэг сумын ЗДТГ | 1 | 0 | | | | | | | 1 | |
| **НИЙТ ДҮН** | | **1** | **0** | | | | | | | **1** | |